



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/706

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2020 оны II/04 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2023 оны XI/03 дугаар хуралдаанаар батлагдсан “Аймгийн төрийн албаны Хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр”, аймгийн Засаг даргын “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай” А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас Булган аймагт “Цахим аймаг-бодлогын зөвлөмж” арга хэмжээний сургалтад аймгийн бүх агентлаг, сумдын төрийн албан хаагчдын төлөөллийг оролцуулан үр дүнтэй зохион байгуулсугай.

2.Сургалтыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө батлуулж, сургалтад шаардагдах 825,000 (найман зуун хорин таван мянга) төгрөгийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардлыг “Аймгийн төрийн албаны Хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр”-өөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



10. Аймгийн Засаг даргын 2023 оны
дүгээр сарын 05 -ний өдрийн А/706
тоот захирамжийн хавсралт



СУРГАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Үдийн цай	110	7,500	825,000
	Нийт			825,000